

ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН G0204-МОН ТӨСЛИЙН НЭГЖИЙН ХЭРЭГЦЭЭНД ТАВИЛГА ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Огноо: 2019 оны 4-р сарын 18

№ МОН-0204-2019-01

Улаанбаатар хот

Энэхүү МОН-0204-2019-01 дугаартай гэрээг нэг талаас Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төслийн удирдах нэгж /цаашид “худалдан авагч” гэх/, нөгөө талаас Би Эс Би /цаашид “нийлүүлэгч” гэх/ нар харилцан тохиролцсоны үндсэн дээр 2019 оны 4-р сарын 18-ны өдөр дараах нөхцөлөөр байгуулав.

Худалдан авагч тал нь дараах хүснэгтээр үзүүлсэн барааг Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төслийн удирдах нэгжид санал болгосон нэмүү өртгийн татвар хассан 15,251,414.61 (арван таван сая хоёр зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун арван дарван төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөг /цаашид “гэрээний дүн”/-ийн үнээр нийлүүлэх саналыг хүлээн зөвшөөрсөн

| № | Нэр | Тоо ширхэг |
|----|--|------------|
| 1 | Даргын ширээ (туслах шүүгээний хамт) | 1 |
| 2 | Хурлын ширээ | 1 |
| 3 | Даргын сандал /дугуйтай, өндөр түшлэгтэй/ | 1 |
| 4 | Ханын шүүгээ босоо /битүү хаалган нүүртэй/ | 1 |
| 5 | Ханын шүүгээ хэвтээ | 1 |
| 6 | Ханын шүүгээ босоо /шилэн нүүртэй/ | 1 |
| 7 | Мэргэжилтний ажлын ширээ | 4 |
| 8 | Тумбочка | 4 |
| 9 | Туслах шүүгээ /ширээнээс өндөргүй/ | 4 |
| 10 | Сандал /дугуйтай/ | 4 |
| 11 | Уулзалтын өрөөний буйдан | 2 |
| 12 | Ширээний туслах шүүгээ | 4 |
| 13 | Төмөр шүүгээ /босоо, цоожтой/ | 2 |
| | Нийт | 30 |

Гэрээний нөхцөл:



1. Дараах баримт бичгийг гэрээний салшгүй хэсэг гэж ойлгоно. Үүнд:
 - а) Үнийн санал; Нийлүүлэх нөхцөл, Техникийн нөхцөл;
 - б) Нэмэлт өөрчлөлтүүд /байгаа тохиолдолд/;
2. Энэхүү гэрээнд заасан худалдан авагчийн талаас хийгдэх төлбөрийн дагуу нийлүүлэх барааг энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу нийлүүлж, гэрээнд заасан гэмтэл доголдлыг арилгах үүрэг хүлээн

энэхүү гэрээг байгуулж байна.

3. Худалдан авагч нь энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу нийлүүлсэн бөгөөд доголдлыг арилгасныг үндэслэн төлбөр хийх үүрэг хүлээж байна.

Дээрх тохиролцсон нөхцөлийг баталж, Монгол улсын хуулийн дагуу энэхүү дээр заасан өдөр гэрээг байгуулав

Худалдан авагчийн гарын үсэг/тамга

Б.Оюун

Төслийн зохицуулагч

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо,

Макс цамхаг барилга” 4/4 101/102 тоот

Утас/факс: 976-11-310916, 310932

И-мэйл: 13388@pmu.mn

Нийлүүлэгчийн гарын үсэг/тамга:




С.Байгаль

Санхүүгийн захирал

БСБ Оффис мебелийн дэлгүүр

Нарны зам-16, 5-р хороолол

3-р хороо, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар хот

Утас: 7509-0272

Факс: 70008997

off.mebcash@bsb.mn

НИЙЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ, ХУВААРЬ

Төслийн нэр: Омнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төсөл

Худалдан авагч: Төслийн удирдах нэгж

Багцын дугаар: МОН-0204-2019-01

| № | Нэр | Тоо ширхэг | Нэгж үнэ (НӨАТ ороогүй) | Нийт үнэ (НӨАТ ороогүй) | Нийт НӨАТ | НӨАТ орсон Нийт үнэ | Нийлүүлэх хугацаа |
|----|--|------------|-------------------------|-------------------------|------------|---------------------|---|
| 1 | Даргын ширээ | 1 | 2,401,187.27 | 2,401,187.27 | 240,118.73 | 2,641,306.00 | Гэрээний төлбөрийг бүрэн төлж дууссан өдрөөс хойш 7 хоногийн дотор. |
| 2 | Хурлын ширээ | 1 | 1,597,914.55 | 1,597,914.55 | 159,791.46 | 1,757,706.01 | |
| 3 | Даргын сандал /дугуйтай, өндөр түшлэгтэй/ | 1 | 563,914.55 | 563,914.55 | 56,391.46 | 620,306.01 | |
| 4 | Ханын шүүгээ босоо /битүү хаалган нүүртэй/ | 1 | 837,369.09 | 837,369.09 | 83,736.91 | 921,106.00 | |
| 5 | Ханын шүүгээ хэвтээ | 1 | 683,550.91 | 683,550.91 | 68,355.09 | 751,906.00 | |
| 6 | Ханын шүүгээ босоо /шилэн нүүртэй/ | 1 | 726,278.18 | 726,278.18 | 72,627.82 | 798,906.00 | |
| 7 | Мэргэжилтний ажлын ширээ | 4 | 307,550.91 | 1,230,203.64 | 123,020.36 | 1,353,224.00 | |
| 8 | Тумбочка | 4 | 282,000.00 | 1,128,000.00 | 112,800.00 | 1,240,800.00 | |
| 9 | Туслах шүүгээ /ширээгээс өндөргүй/ | 4 | 358,823.64 | 1,435,294.56 | 143,529.46 | 1,578,824.02 | |
| 10 | Сандал /дугуйтай/ | 4 | 281,914.55 | 1,127,658.20 | 112,765.82 | 1,240,424.02 | |
| 11 | Уулзалтын ерөөний буйдан | 2 | 700,641.82 | 1,401,283.64 | 140,128.36 | 1,541,412.00 | |
| 12 | Ширээний туслах шүүгээ | 4 | 358,823.64 | 1,435,294.56 | 143,529.46 | 1,578,824.02 | |
| 13 | Төмөр шүүгээ /босоо, цоожтой/ | 2 | 341,732.73 | 683,465.46 | 68,346.55 | 751,812.01 | |
| | Нийт | 30 | | 15,251,414.61 | | 16,776,556.07 | |

2. Тогтмол үнэ: Үнийн саналд заасан үнэ тогтмол байх бөгөөд өөрчлөлт оруулахгүй.

3. Нийлүүлэлтийн хуваарь: Нийлүүлэлтийн хугацааг дээр заасны дагуу тогтоох ба гэрээ байгуулснаас хойш 2 долоо хоногоос хэтрэхгүй.
4. Даатгал: Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь үйлдвэрлэгчийн буруутай ажиллагаа, тээвэр, хадгалалт болон нийлэлттэй холбоотой үүсэх гэмтэл, алдагдахаас урьдчилан сэргийлж бүх эрсдлийг багтаан чөлөөтэй хөрвөх валютаар даатгагдсан байна.
5. Холбогдох хууль тогтоомж: Гэрээг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тайлбарлаж, ойлгоно.
6. Маргаан зохицуулах: Гэрээний хэрэгжилттэй холбоотой үүсч болох аливаа маргааныг талууд нөхөрсгөөр шийдвэрлэхийг эрмэлзэж, хүчин чармайлт тавина. Аливаа маргааныг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрэнэ.
7. Нийлүүлэлтийн баримт бичгүүд: Нийлүүлэлттэй холбогдуулан худалдан авагч талд Нийлүүлэгчээс дараах баримт бичгийг хүргүүлнэ. Үүнд:
 - (i) Нийлүүлэгчийн зүгээс ирүүлэх нэхэмжлэхтэй хамт барааны нэр төрөл үзүүлэлт, тайлбар, нэгж үнэ болон нийт тоо ширхгийг заасан тайлбарын хамт;
 - (ii) Үйлдвэрлэгчийн чанарын баталгааны гэрчилгээ; ба
 - (iii) Гарал үүслийн гэрчилгээ.
8. Төлбөр: төлбөрийг дараах хэлбэрээр хийнэ:
 - a) Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсныг үндэслэн гэрээний дүнгийн 20 хувийг буюу MNT3,050,282.92 (гурван сая тавин мянга хоёр зуун наян хоёр төгрөг ерэн хоёр мөнгө);
 - b) Үлдэгдэл 80 хувь буюу 12,201,131.69 (арван хоёр сая хоёр зуун нэгэн мянга нэг зуун гучин нэгэн төгрөг жаран есөн төгрөг)-ийг Захиалагчийн 2019 оны 5-р сарын төсөв батлагдан, дансанд шилжсэн даруйд.
9. Баталгаа: Барааг нийлүүлснээс хойш 18 сарын хугацаанд чанарын баталгаа өгнө.
10. Гологдол: Үйлдвэрлэгчийн гологдлыг худалдагчид мэдэгдсэнээс 30 хоногийн дотор үнэ төлбөргүй засварлана. Гологдлыг засварлах засварын газрын байршил нь:

Хаяг: БСБ Оффис мебелийн дэлгүүр
Нарны зам-16, 5-р хороолол
3-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот
11. Давагдашгүй хүчин зүйл: Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан гэрээний үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл хугацаа хоцорсонтой холбогдон тооцогдох алданги, цуцлахтай холбогдсон хариуцлагах үлээхгүй.

Энэхүү гэрээнд “Давагдашгүй хүчин зүйл” гэдгийг Нийлүүлэгчийн нөлөөнөөс ангид, урьдчилан таамаглах боломжгүй үйл явдлыг хэлнэ. Үүнд дараах болон үүгээр зөвхөн хязгаарлагдахгүй хүчин зүйлс багтана: хувьсгал, түймэр, үер, халдварт өвчин, хорио цээрийн дэглэм, тээврийн эмбарго зэрэг орно.


Давагдашгүй хүчин зүйл үүсэх тохиолдолд нилүүлэгч худалдан авагч талд энэ тухай тэр даруй албан бичгээр мэдэгдэнэ. Бусад нөхцөлд гэрээний үүргээ биелүүлэх боломж эрэлхийлж, нийлүүлэгч давагдашгүй нөхцөл хамаарахгүй арга шийдэл хайна.
12. Техникийн шаардлага: (шаардлагатай бол Хавсралтад үзүүлнэ)

- (i) Ерөнхий тайлбар
- (ii) нарийвчилсан үзүүлэлт ба техникийн стандартууд
- (iii) Хүчин чадлын үзүүлэлт

Нийлүүлэгч тал техникийн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн.

13. Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх: Нийлүүлэгч бараа нийлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд 14 хоногийн өмнө урьдчилсан мэдэгдлийг хүргүүлсний үндсэн дээр аливаа алданги тооцолгүй гэрээг цуцалж болно.

Нийлүүлэгчийн нэр : БСБ Трэйдинг ХХК

Баталгаат гарын үсэг: _____ 

Байршил: БСБ Оффис мебелийн дэлгүүр

Нарны зам-16, 5-р хороолол

3-р хороо, Сүхбаатар дүүрэг

Огноо: 2019 оны 04-р сарын 18

Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төслийн нэгжийн хэрэгцээнд авах тавилгад тавигдах шаардлага

Үнийн саналд дараах шаардлагыг хангаж буйг тус бүрт нь баримтаар баталгаажуулж саналдаа хавсаргана. Зөвхөн доор дурдсан шаардлагад хамаарах мэдээллийг ирүүлнэ үү.

I. Нийлүүлэгчид тавигдах шаардлага

1. Нийлүүлэгч нь Монголын зах зээлд 5 жилээс доошгүй хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байх.
2. Нийт тавилганд чанарын багалгаа 18 сар байх.
3. Засварын төвтэй байх.
4. Бараа нь нийлүүлэгчийн складанд бэлэн байх.

II. Тавилгад тавигдах шаардлага:

1. Загвар хийц, дизайн
 - a. Өнгөний шийдэл нь тус төслийн хуучин тавилгатай өнгөний хувьд зохицсон байх.
 - b. Тухайн санал болгож буй загвар зах зээлд шинээр борлуулагдаад 2 -с ихгүй жил үйлдвэрлэгдсэн загвар байх.
 - c. Эргономикийн хувьд монгол хүний биеийн хэмжээ, онцлогийг харгалзан үзсэн/түүнд тохирсон байх.

2. Техникийн үзүүлэлт

- a. Хэмжээ: Дор дурдсан тавилгын хэмжээг тухайн өрөөний хэмжээ, байрлал, өндөр, дотоод заслын шийдэлтэй зохицуулж санал болгоно. Хэмжээний хувьд одоо ашиглаж байгаа хуучин тавилгаас 5 хувиар хэлбэлзэж болно. Одоо ашиглаж байгаа тавилга болон өрөөний зохион байгуулалтын зургийг хавсаргав.

i. Төслийн зохицуулагчийн өрөөний тавилгын багц /1 багц/
Нэгдсэн нэг загварын байх.

- 1) Даргын ширээ;
- 2) Хурлын ширээ;
- 3) Даргын ширээний туслах шүүгээ /ширээтэй хамт нэг угсармал/;
- 4) Даргын сандал /дугуйтай, өндөр түшлэгтэй/;
- 5) Ханьн шүүгээ босоо /битүү хаалган нүүртэй/;
- 6) Ханьн шүүгээ хэвтээ;
- 7) Ханьн шүүгээ босоо /шилэн нүүртэй/.

ii. Төслийн мэргэжилтний тавилгын багц

- 1) Мэргэжилтний ажлын ширээ /4 ширхэг/
- 2) Тумбочка /4 ширхэг/
- 3) Туслах шүүгээ /ширээнээс өндөргүй/ /4 ширхэг/
- 4) Сандал /дугуйтай/ /4 ширхэг/
- 5) Уулзалтын өрөөний богино буйдан 3 хүн суух /2 ширхэг/
- 6) Ширээний туслах шүүгээ /4 ширхэг/
- 7) Төмөр шүүгээ /босоо, цоожгой/ /2 ширхэг/

b. Материал

Тавилгыг ашиглах ажилтны иууд хүрэлцэх гадаргуу нь модон эсхүл нийлэг материал ашигласан байх ба ажилтны тав тухтай ажиллахад хайрахгүй, хоргүй, үнэр ялгарах, будгийн бэхжилт сайтай байна. Зориулалтын дагуу ашиглалтын явцад хатах, сэнсэрч хотойх, мушгирах зэрэг хэв гажилтад орохгүй байхыг баталгаажуулна.

- c. Тавилгын үйлдвэрлэлд байгальд ээлтэй материал болон технологи ашигласан бөгөөд ус чийгний хамгаалалт бүхий гадаргуутай бол давуу тал болно. Үйлдвэрлэгч болон бүтээгдэхүүн ISO стандарт хангасан байвал давуу тал болно.
- d. Холбоос боолт, бэхэлгээ, нугас, түгжээ, хөл, дугуй, жийргэвч, зөөлөвч нь өндөр чанарын зориулалтын материалаар хийсэн, даац өндөртэй байх ба чанарын туршилтын дүгнэлтийг үйлдвэрлэгчээс ирүүлсэн байх.

III. Нийлүүлэх нөхцөл

- 1. Барааг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 /таван/ хоногийн дотор нийлүүлнэ. Тээвэрлэлтийн зардлыг болон нийлүүлэлт, суурилуулахтай холбогдох бүх эрсдлийг нийлүүлэгч бүрэн хариуцах буюу incoterms DDP нөхцөлөөр нийлүүлнэ. Гэрээний төслийг хавсаргав.
- 2. Нийлүүлэх бараа нь шинэ бөгөөд өмнө нь ашиглагдаагүй байна.

IV. Бусад

Тус төсөл нь Нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөгдөх тул гэрээ байгуулсан тохиолдолд төлбөрийг татваргүй дүнгээр хийнэ.